



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 11528

Есөнбулаг

Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд  
оролцох сурагч Б.Буянхишигийн замын  
зардалд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 34 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.4.4, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.4 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өсвөрийн шатарчдын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох сурагч Батпэлдэнгийн Буянхишигийн замын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

